



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2015 оны 06 сарын 10 өдөр

Дугаар Д/170

Хэрлэн сум

Иргэний нэхэмжлэгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, Монгол улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.253900404 бүртгэлийн дугаартай хэрэгт иргэний нэхэмжлэгчээр тус сумын Засаг даргын Тамгын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч Дугарсэдэдийн Буянбат томилсугай.

2.Хуульд заасан эрх, үүргийг хэрэгжүүлж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож, хохирлыг барагдуулж ажиллахыг иргэний нэхэмжлэгч (Д.Буянбат)-д даалгасугай.

3.Иргэний нэхэмжлэгч Д.Буянбат хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрхийг хангах, унаа, шатахууны зардлыг тухай бүр олгохыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Лхагвабаатар)-д даалгасугай.

ДАРГА



Д.ЭРДЭНЭБААТАР